



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/637

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 45.2 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшигч иргэн Дайданзан овогтой Туяа (ЦГ65040804)-ийн хүсэлтийн дагуу “Газар эзэмшүүлэх, газар эзэмших эрхийн гэрчилгээ шилжүүлэх тухай” аймгийн Засаг даргын 2016 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/258 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралтын 1 дэх хэсэгт заасан Мөрөн сумын 8 дугаар баг Эрүүл мэндийн газрын баруун талд байршилтай эмийн сангийн зориулалтаар эзэмшүүлсэн 2373.4м² газрын газар эзэмшигчийн нэрийг “Увдис эмийн сан” гэж захирамжийн илэрхий алдаатай гарсан байх тул тухайн газар эзэмшигчийн нэрийг Дайданзан овогтой Туяа (ЦГ65040804) гэж засаж гарган 6712016392 нэгж талбарын дугаартай 2379 м² талбайн хэмжээтэй газрын зориулалтыг газрын кадастрын цахим системийн газрын нэгдмэл сангийн ангилалд тохируулан “худалдаа, нийтийн үйлчилгээ”-ны зориулалттай болгон өөрчилж газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг үлдсэн 7 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/258 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралтын 1 дэх хэсгийг хүчингүй болгосугай.

3. Дээрх захирамжаар газрын кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулж газар эзэмшигч иргэн Дайданзан овогтой Туяа (ЦГ65040804)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Захирамж2024

6712012030